

АРХАНГАЙ АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН  
ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/2023 оны жилийн эцсийн байдлаар/

2024.01.20.

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Архангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг үнэлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах, удаашралтай, хэрэгжилт хангалтгүй зорилт, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг тодорхойлох, дүгнэлт зөвлөмж өгөх, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэслэл, арга зүй**

Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, “Тогтоолын өөрчлөлтөд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолын 6.2.2-т заасан зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол 90.0 хувь, тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол 70.0 хувь, тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол 50.0 хувь, тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол 30 хувь, тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол биелэлтийг “0” хувь гэсэн үнэлгээний аргачлалыг ашиглаж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн, дүгнэлт**

Архангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 10 дугаар тогтоолоор батлуулсан.

Мөн Архангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, түүний хүрэх түвшинг 2025 оноор тодорхойлсон төлөвлөсөн нь тухайн жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх боломжгүй нөхцөл үүсэж хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжөөр 2023 онд аймгийн Засаг даргын захирамжаар шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшинг он оноор шинэчлэн баталсан байна.

Үндсэн чиглэл нь бүтцийн хувьд Үндэсний нэгдмэл үнэт зүйл, Хүний хөгжил, Амьдралын чанар ба дундаж давхарга, Эдийн засаг, Засаглал, Ногоон хөгжил, Амар тайван, аюулгүй нийгэм, Орон нутгийн хөгжил гэсэн 8 том бүлэг, Үндэсний бахархал, эв нэгдэл, нүүдлийн соёл иргэншилт Монгол, Боловсрол, Эрүүл мэнд, Гэр бүл, Монгол

хүний удмын сан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, Эрүүл, идэвхитэй амьдралын хэв маяг, Санхүү төсөв, Өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэл, Ухаалаг бүтэц, Цахим аймаг, Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба, Байгаль орчин, Зэвсэгт хүчин, Хүн, нийгмийн амар тайван байдал, Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, Дэд бүтэц, Аялал жуулчлал, Тогтвортой хөдөө аж ахуй гэсэн 19 дэд бүлэг, 19 бодлогын зорилт, 103 дэд зорилттойгоор батлагдсан.

Архангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 103 дэд зорилтын хэрэгжилтэд 2023 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд зорилтот түвшинд бүрэн хүрсэн буюу 100 хувьтай 32 зорилт, хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа буюу 90.0 хувьтай зорилт **46**, тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу 70.0 хувьтай зорилт **15**, бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн буюу 50.0 хувьтай зорилт **7**, бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа буюу 30 хувьтай зорилт **3**, хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй “0” хувьтай огт хэрэгжээгүй зорилт байхгүй нийт зорилтуудын хэрэгжилтийн дундаж **85.3** хувь байна.

Үнэлгээг хүснэгтээр харуулбал:

Салбарын нэр	Бодлогын зорилт	Дэд зорилт	Хэрэгжилтийн явц						Хэрэгжилтийн дундаж хувь
			Үүний дотор						
			100%	90%	70%	50%	30%	0%	
<b>НЭГ. ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ</b>									
1.1. Үндэсний бахархал, эв нэгдэл, нүүдлийн соёл иргэншилт монгол	1	5	3	2	-	-	-	-	<b>96</b>
<b>ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ</b>									
2.1. Боловсрол	1	8	6	2	-	-	-	-	<b>97.5</b>
2.2. Эрүүл мэнд	1	5	-	4	1	-	-	-	<b>86</b>
2.3. Гэр бүл	1	2	1	-	1	-	-	-	<b>85</b>
2.4. Монгол хүний удмын сан	1	2	-	1	1	-	-	-	<b>80</b>
<b>ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА</b>									
3.1. Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт	1	5	2	3	-	-	-	-	<b>94</b>
3.2. Эрүүл, идэвхитэй амьдралын хэв маяг	1	4	1	3	-	-	-	-	<b>92.5</b>
<b>ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ</b>									
4.1. Санхүү төсөв	1	4	2	2	-	-	-	-	<b>95</b>
4.2. Өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1	1	-	-	1	-	-	-	<b>70</b>
<b>ТАВ. ЗАСАГЛАЛ</b>									
5.1. Ухаалаг бүтэц	1	3	-	3	-	-	-	-	<b>90</b>
5.2. Цахим аймаг	1	5	4	-	1	-	-	-	<b>94</b>
5.3. Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба	1	4	2	1	1	-	-	-	<b>90</b>
<b>ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ</b>									
6.1. Байгаль орчин	1	12	3	6	-	2	1	-	<b>80.8</b>
<b>ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ</b>									
7.1. Зэвсэгт хүчин	1	3	1	2	-	-	-	-	<b>93.3</b>
7.2. Хүн, нийгмийн амар тайван байдал	1	6	4	1	1	-	-	-	<b>93.3</b>
<b>НАЙМ. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ</b>									
8.1. Газрын харилцаа, барилга, хот байгуулалт	1	6	-	1	4	1	-	-	<b>70</b>
8.2. Дэд бүтэц	1	9	-	5	2	1	1	-	<b>74.4</b>
8.3. Аялал жуулчлал	1	6	-	4	1	1	-	-	<b>80</b>
8.4. Тогтвортой хөдөө аж ахуй	1	13	3	6	1	2	1	-	<b>80</b>
<b>Нийт</b>	<b>19</b>	<b>103</b>	<b>32</b>	<b>46</b>	<b>15</b>	<b>7</b>	<b>3</b>	<b>-</b>	<b>85.3</b>

2023 оны үнэлгээнээс харахад 19 салбарын дэвшүүлсэн 19 бодлогын зорилтын 4.2. Өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэл, 8.1. Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, 8.2. Дэд бүтцийн чиглэлээр дэвшүүлсэн бодлогын зорилтуудын дундаж 70-74,4 хувьтай буюу хамгийн бага хувьтай байна.

Бусад салбаруудын дэвшүүлсэн бодлогын зорилтуудын дундажыг авч үзвэл зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй ч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, гол үр гарч эхэлж байна гэж үзлээ.

Харин “Тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол “0” хувьтай үнэлэгдсэн зорилт байхгүй хэмжээнд хэрэгжиж эхлээгүй, шинээр хэрэгжиж эхэлж байгаа, хэрэгжих хугацаа болоогүй гэх мэт шалтгаанаар хэрэгжилт хангалтгүй бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа буюу 30 хувьтай зорилтуудыг дурьдвал:

№	Зорилтын нэр	Шалтгаан тайлбар
1	Агаарын бохирдлыг бууруулах хүрээнд гэр хорооллын дулааны хэрэглээг утаагүй, шахмал түлшээр хангах ажлыг бодлогоор дэмжин ажиллана.	Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох, бүсэд мөрдөх журмыг баталсан.
2	Аймгийн төвийн гэр хорооллын шинэчлэл, дэд бүтцийг сайжруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	Тендер зарлагдан гүйцэтгэгчээр “Энигма констракшн” ХХК шалгаран зураг төслийн ажил хийгдэж байна. Төсөв санхүүгийн шалтгаанаар зорилтот түвшинд хэрэгжээгүй.
3	Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэр байгуулна.	2 суманд мал нядалгааны цэг байгуулах ажил хийгдэж байна.

Бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн буюу 50.0 хувьтай зорилтуудыг дурьдвал:

1	Архангай аймгийн Хог хаягдлын менежментийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Бүх нийтийн хог цэвэрлэгээ, иргэдэд нөлөөлөх нөлөөлөл, сурталчилгааны ажил тогттол хийгдэж байна. Хөтөлбөрийн хэрэгжилт 30 хувьтай.
2	Гэр хороолол, хөдөөгийн хот айл, өрх, аялал жуулчлалын бүсийн ариун цэврийн байгууламжийг сайжруулан, хөрсний бохирдлыг бууруулж, “Эко жорлон” арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Аялал жуулчлалын 2 бүсэд 14 ширхэг стандартын шаардлага хангасан эко нойл шинээр барьсан.
3	Цэцэрлэг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлж, төлөвлөгдсөн байршлуудад иргэдийн оролцоотойгоор дахин төлөвлөлтийн ажлыг эхлүүлж орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Дахин төлөвлөлтийн ажлыг 4-н байршилд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Тус байршлуудын 50 гаран орон сууцны өмчлөгч, эзэмшигчдийн төлөөллүүдтэй оролцуулж төслийн төлөвлөгөөнд санал авч зураг төслийг эцсийн байдлаар боловсруулан дуусгасан.  Батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер зарлахаар бэлтгэн ажлыг хангаж байгаа.  Эрдэнэбулган сумын 2 байршилд шинэ хорооллын дэд бүтцийн ажлуудын ажлын зураг хийлгэх, угсралтын хөрөнгийг шийдүүлэх талаар БХБЯ-нд санал хүргүүлсэн.
4	Цэцэрлэг хотод Дулааны станцыг барьж ашиглалтад оруулах асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэж, агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ авч ажиллана.	Тендэр зарлагдсан.
5	“Цахим аялал жуулчлал” арга хэмжээ хэрэгжүүлнэ.	Аймгийн 1100 газрын мэдээлэл бүрэн цахимжсан. Архангай аймгийн тойрон аяллын 30 маршрут, аялал жуулчлалын хөтөч номыг QR код уншуулан ашиглахаар болгосон.
6	“Цахим хөдөө аж ахуй” арга хэмжээ хэрэгжүүлнэ.	4 төрлийн цахим системийг хэрэгжүүлж эхэлсэн.

7 Орон нутгийн иргэд хүнсний ногоо, жимс Хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн хөтөлбөрийн жимсгэний хэрэгцээгээ өөрөө хангах, зоорь, хэрэгжилт 52.8 хувьтай. хүлэмжийн аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжиж, “Өрхийн тариалан” арга хэмжээг жил бүр зохион байгуулж хэрэгжүүлнэ.

### **Дөрөв. Дүгнэлт, санал, зөвлөмж**

Архангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2023 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дэд зорилтуудын 30 орчим хувь нь бүрэн хэрэгжсэн байгаа бол бодлогын зорилтууд нь тухайн оныхоо дэвшүүлсэн зорилтдоо бүрэн хүрээгүй боловч хяналт-шинжилгээний зөвлөмжийг хэрэгжүүлж төлөвлөлтийг дахин хийснээр өмнөх онуудад хэрэгжилт хангалтгүй байсан зорилтуудын хэрэгжилт сайжирч, тодорхой үр дүн гарч эхэлсэн байна гэж дүгнэлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээнд дараах санал, зөвлөмжийг гаргаж байна.

1. Хэрэгжилт хангалтгүй байгаа зорилтуудыг цаашид хэрэгжүүлж үр дүнд хүргэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах, холбогдох төсөв санхүүг шийдвэрлүүлэх, хувийн хэвشلүүд, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, үйл ажиллагааг дэмжих ажлуудыг бодлогын хэмжээнд хэрэгжүүлэх,

2. Аймгийн Засаг даргын тамгын газрын хэлтсүүд, сумдын Засаг даргын амгын газар, харьяа агентлагуудын ажлын уялдаа холбоогоо сайжруулах, хамтарч ажиллах нь зүйтэй.

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**